



АРЛИНГТОНЫ УЛСЫН СУРГУУЛЬ СУРГАЛТ АРГА ЗҮЙН ХЭЛТЭС

“EARLY CHILDHOOD” АЛБА

Эрхэм эцэг эх/Асран хамгаалагч Танаа,

Эцэг эхчүүдийг тодорхой мэдээллээр хангаж байх зорилгоор “Early Childhood” Албанаас эрхлэн хоёр жил тутамд гардаг дүнгийн мэдээлэх хуудсанд хавсралт болгож **Цэцэрлэг ангиудийн сурлагын үнэлгээний тайлбарыг (KIDS)** хэвлэж гаргадаг билээ.

Эдгээр дүнгийн мэдээлэх хуудсанд буй үзүүлэлтүүд буюу үнэлгээнүүд нь цэцэрлэг ангид эзэмшвэл зохих ур чадвар, хичээлийн агуулгыг тусган харуулж байгаа юм. Цэцэрлэг ангид зориулсан Виржиниа муж улсын Сургалтын Стандарт (**SOLS**) болон ажил хөдөлмөрийн дадал зуршил, нийгмийн хөгжил зэрэг нь хичээлийн салшгүй бүрдэл хэсэг юм. Цэцэрлэг ангид зориулсан Виржиниа муж улсын Сургалтын Стандартын (**SOLS**) дэлгэрэнгүй тайлбарыг Виржиниа муж улсын Боловсролын газрын дараах вэб хуудаснаас танилцаж болно. <http://www.doe.virginia.gov/VDOE/Instruction/sol.html> .

Үнэлгээний тайлбар:

Цэцэрлэг ангиудийн дүнгийн хуудсанд тавигдах үнэлгээний кодууд нь хүүхдийн сурлагын явцад үнэлгээ өгөх зорилготой болно. Эдгээр үнэлгээ нь хичээлийн агуулга, хүүхдийн эзэмшвэл зохих ур чадварт суурилж тухайн сурагчийн сурлагын ахицыг илэрхийлж байгаа юм.

Цэцэрлэг ангиудын дүнгийн хуудсанд хэрэглэх үнэлгээний кодууд	
M- шаардлага хангаж буй	Сахилга бат, сурлагын шаардлагыг байнга хангаж буй Сурагч нь хичээлийн агуулгыг ойлгож, сурах арга барилд суралцаж буйгаа бие даан илэрхийлэн харуулж буй
P- ахиц гаргаж буй	Хүүхэд нь сахилга бат, сурлагаар ахиц гаргаж буй Сурагч нь шаардлагатай ур чадвар, сурлагын стратеги, үндсэн агуулгыг ойлгож буйгаа үе үе илэрхийлэн харуулж, хэрэгжүүлж буй Сурагч нь сурлагын стандартыг бүрэн бус хангаж буй
B- ахиц гаргаж эхэлж буй	Сурагч сахилга бат, сурлагадаа ахиц гаргаж эхэлж буй Сурагч нь хичээлийн агуулгыг ойлгож, сурах арга барилд суралцаж эхэлж байгаа бөгөөд энэ зорилтыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд багшийн оролцоо, дэмжлэг шаардлагатай.
N- ахиц хараахан гараагүй	Сурагч сахилга бат, сурлагадаа хараахан ахиц гаргаагүй.
NI- ахиц огт гараагүй	Мэдлэг чадвараа бүрэн харуулаагүй болно.

Хүүхэд бүр өсч хөгжих өөрийн онцлогтой хувь хүмүүс юм. Нэг ангид сурч буй хүүхдүүд бусад ангийн хүүхдүүдээс өөр байх нь бий. **Цэцэрлэг ангиудын дүнгийн мэдээлэх хуудас** болон **Цэцэрлэг ангийн сурлагын үнэлгээний тайлбарын (KIDS)** аль аль нь сургууль болон сурагчийн ар гэрийн хооронд нягт харилцаа холбоо тогтооход чиглэгдсэн байдаг. Сургууль, сурагчийн ар гэр түнш болж хамтран ажиллаж чадвал хүүхдүүд сурч боловсрох, амжилт гаргах нэгэн таатай нөхцөл болох билээ. Ийм учраас, та бүгдийг эдгээр зорилтуудтай сайтар танилцахыг хичээнгүйлэн хүсч байна.

Хэрэв танд асууж тодруулах зүйл байвал, өөрийн хүүхдийн ангийн багш болон “Early Childhood” албатай дараах утсаар холбо барина уу. Утас: 703-228-8632

Хүндэтгэсэн,

Доктор Донна Снайдер (Dr. Donna Snyder) “Early Childhood”, Бага боловсролын Албаны Захирал
Кэйт Грахам (Kate Graham) “Early Childhood” Албаны Зохицуулагч